



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 23 өдөр Дугаар18

Хэрлэн сум

XVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 18 дугаар хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 91,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын дархлаажуулалтын талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2.Караоке, саун, сүм хийдийн үйл ажиллагааг нээх эсэх талаар хэлэлцэх,

Мэргэжлийн хяналтын газар

3.Аймгийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах эсэх талаар хэлэлцэх,

Боловсрол, соёл урлагийн газар

4.Хилийн Эрээнцав боомтын хяналтын цэгийг ажиллуулах эсэх талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

5.Оношлуур худалдан авах талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар



6.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Сумын Засаг дарга нарт:

1.1.Вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж ажиллахыг,

/  / М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

1.2.Вакцинжуулалтын бүртгэлийн ажилд багуудын ажлын албаны албан хаагч нарыг томилж ажиллуулах, зарим төрийн байгууллагыг вакцин хийх цэгээр ашиглахыг,

Хоёр.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал-д:

2.1.Аймгийн Засаг даргын 2020 оны А/567 тоот захирамжийг хүчингүй болгох тухай аймгийн Засаг даргын захирамж боловсруулж батлуулахыг,

Гурав.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдад Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны А/24 дугаар тушаалын дагуу хичээлийн хоцрогдлыг нөхөх танхимын давтлага хичээлийг эхлүүлэхийг зөвшөөрөх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:



3.2.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан түр журмын дагуу шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг зөвшөөрч 7 хоног тутам хяналт тавих, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээг авч ажиллахыг,

Дөрөв.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

4.1.Цагдаагийн газрын саналын дагуу цаашид Хилийн Эрэнцав боомтын хяналтын цэгийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэн явуулахыг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

4.2.Хилийн Эрэнцав боомтоор нефть импортлогч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж тус боомтод нэмэлтээр

/  / М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

хяналт тавьж буй Цагдаагийн газрын албан хаагч нарын байр, хоол, томилолт, халдвар хамгааллын хэрэгсэл, цахилгаан, түлш, шатахуун зэрэг үйл ажиллагааны шаардагдах зардлыг шийдвэрлүүлэхийг,

Тав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа.

5.1.Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Оношлуур худалдан авах тухай" хүсэлтийн дагуу 525 ширхэг оношлуур худалдан авах зардал 9,870,000 төгрөгийг шийдвэрлүүлэх хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг,

Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

5.2.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газраас Улаанбаатар хотоос ачаа тээвэрлэж ирсэн 89 тээврийн хэрэгсэлд хяналт тавихад гарсан шатахууны зардал 890,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг,

Гаалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр,

Хилийн дугаар ангийн захирагч, хурандаа О.Баттулга, Хилийн дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт:

5.3.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хариу ирүүлэх тухай" 2021 оны 864 дүгээр албан бичгийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээллийг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулж Улсын Онцгой комисст хариуг хүргүүлэхийг,



Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.4.Чулуунхороот сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Чиглэл хүсэх тухай" албан бичгийн дагуу Чулуунхороот сумын Засаг дарга, Онцгой комиссын даргад өмнөх хугацааны төлбөрийг нөхөж төлөх боломжгүй, цаашид өндөр өртгөөр түрээслэх боломжгүй тухай албан бичгээр хариу хүргүүлэхийг,

5.5.Матад, Халхгол суманд ажилласан ажлын хэсгийн шатахууны зардал 360,000 төгрөгийн шатахууны талоныг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Мэргэжлийн хяналтын газарт олгохыг,

5.6.Болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын бэлтгэл, бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилгоор уснаас эрэн хайх, аврах ажиллагааны усны шумбалтын өвөл, зуны иж бүрэн хувцас, автомашины татагч лебодка худалдан авах талаар судалж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

5.7.Өвлийн улиралд усны гүний шумбалтыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэсэн Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын 1 усчин аврагч

/  / М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

албан хаагчийг шагнаж урамшуулах тухай саналыг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

5.8."Степ голд" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Ажлын хэсэг ажиллуулах" хүсэлтийн дагуу шаардагдах зардлыг тухайн компани шийдвэрлэсэн тохиолдолд мэргэжлийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж ажиллуулахыг зөвшөөрөв,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

5.9.Тээврийн хэрэгслийн ослын улмаас байгальд шатахуун асгарч хохирол учирсантай холбогдуулан Байгаль орчны улсын байцаагч, авто тээврийн улсын байцаагч нарын мэдэгдлийг шатахуун тээвэрлэлт хийж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад албан бичгээр хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙКОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА